



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/345

Булган сум

Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Мөнхбат (ГД66021979)-ын Булган сум 2 дугаар баг Мал эмнэлэг 1 дүгээр гудамж 105а тоотод байршилтай 6308003626 нэгж талбар бүхий орон сууц зориулалтаар эзэмшиж буй 1478 м2 газраас 270 м2 газрыг Х.Мөнхбат (ГЮ66062674)-д шилжүүлэн 15 жилийн хугацаагаар эзэмшүүлж, үлдсэн 1208 м2 газрыг нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Х.Мөнхбаттай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн Д.Мөнхбаттай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР